

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжиж эхэлснээс хойш баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурал (ИНХ)-ын үйл ажиллагаа доголдож, зарим баг, хороодод огт хуралдахгүй болж, иргэдийн Үндсэн хуулийн эрх зөрчигдөж байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.7-д “Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн дараах баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хуралдааныг сум, дүүргийн Засаг дарга шинээр томилогдсоны дараа зохион байгуулна” гэж заасан байна. Хуулийн 32 дугаар зүйлийн 32.7-д зааснаар нутгийн өөрөө удирдах анхан шатны нэгж болох баг хорооны Иргэдийн Нийтийн Хурал сум, дүүргийн Засаг дарга томилогдсоны дараа хуралдах ёстой боловч 2022 оны 01 сарын 01-нээс хойш иргэдийн Нийтийн Хурал хуралдаагүй, хуралдах эрх зүйн үндэсгүй болсон байна. Үүний улмаас орон нутгийн сонгууль 2024 оны 10 дугаар сарын орон нутгийн сонгуулийн дараа ч баг, хороодын ИНХ хуралдаагүй байна.

Үүний улмаас нийслэлийн 204 хороо, орон нутгийн 1,647 багийн иргэдийн нийтлэг эрх ашиг хөндөгдсөн, нутгийн өөрөө удирдах ёсны институц суларч, гүйцэтгэх засаглалын хяналтгүй болсон байна. Иргэдийн Нийтийн Хурлаар тодорхой асуудлыг шийдвэрлэдэг 14 хууль байдаг бөгөөд эдгээр хуулийн хэрэгжилт гацаж байна. Төр дэх иргэдийн хяналт суларч, авлигын индекс буурсаар байна.

Иймд баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлыг Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн хуралдуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд дараах нэмэлт, өөрчлөлтүүдийг тусгалаа.

- ИНХ нь Хурлын дарга, 5–11 гишүүнтэй тэргүүлэгч, болон Иргэний танхим (ажлын алба)-тай байж, гүйцэтгэх засаглал болох Засаг даргаас бие даан үйл ажиллагаа явуулна.
- Хурлын дарга: ИНХ зарлах, хуралдуулах, шийдвэр баталгаажуулах, үйл ажиллагааг хангах.
- Урамшуулал: Засаг даргын үндсэн цалингийн 50% — ажиллах хүн олдохгүй байх практик асуудлыг шийдвэрлэнэ.
- Засаг дарга ИНХ-ын үйл ажиллагаанд оролцохгүй — бие даасан байдал эрх зүйн хувьд баталгаажна.
- Нутаг дэвсгэрийн хүн амын нягтаршил харилцан адилгүй байдлыг харгалзан ирцийн босгыг дараах байдлаар тогтоосон:

Хүснэгт 1. Ирцийн зохицуулалт

Сонгогчдын тоо	Ирцийн доод хэмжээ	Хэрэглэгдэх хүрээ
500 хүртэл	10%	Жижиг хөдөөгийн багуудын тал хувь (медиан 650–750)
501–3,000	5%	Дундаж баг, хороо — 2,500 сонгогчтой бол 125 иргэн хангалттай
3,001–6,000	3%	Том баг, хороо — идэвхтэй оролцоог дэмжинэ
6,001-ээс дээш	250+	Нийслэлийн хороодын тал хувь (медиан 7,200)

- Танхим, цахим, эсхүл хосолсон хэлбэрээр хуралдаан зохион байгуулах боломжийг олгож, иргэдийн оролцооны практик саадыг арилгахаар зохицуулалтыг тусгалаа.
- Баг, хорооны Засаг даргад нэр дэвшүүлэхдээ санал хураалтаар, тухайн баг, хорооны бүртгэлтэй сонгуулийн насны иргэд саналаа өгөх боломжийг олгох зохицуулалтыг тусгасан.
- Мөн хуулийн 56 дугаар зүйлд баг, хорооны Засаг дарга тавих шаардлагыг өөрчилж, аль алинд нь бүрэн дунд боловсрол эзэмшсэн байх зохицуулалтыг тусгасан болно. Энэ нь ижил шатны засаглалд тэгш бус шаардлага тавьж байсан зохицуулалтыг Үндсэн хуулийн тэгш байдлын зарчимд нийцүүлэхэд чиглэнэ.

Хүснэгт 2. Хуулийн зохицуулалтын харьцуулалт

Одоогийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалт	Өөрчлөлтийн үндэслэл
ИНХ-ын хуралдааныг Засаг дарга зарлана — гүйцэтгэх засаглалаас хамааралтай	ИНХ-ын дарга бие даан зарлана — жилийн эхэнд цаглабар батална	<i>Нутгийн өөрөө удирдах ёсны бие даасан байдлыг хангана</i>
"Хуралдааны дарга" — байнгын статусгүй, урамшуулалгүй	ИНХ-ын дарга — Засаг даргын цалингийн 50% урамшуулалтай	<i>Ажиллах хүн олдохгүй байх практик асуудлыг шийднэ</i>
Ирцийн шаардлага нэг хэмжигдэхүүнтэй — жижиг баг, том хороонд адил	4 шатлал: 10% / 5% / 3% / 250 иргэн — хүн амтай уялдсан	<i>Хот, хөдөөгийн онцлогт тохирсон бодит зохицуулалт</i>
Зөвхөн танхимын хуралдаан — хөдөлмөрийн	Цахим болон хосолсон хэлбэр хуульчлагдана.	<i>Баг, хороод боломжоо ашиглан хуралдаан зохион байгуулж,</i>

Одоогийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалт	Өөрчлөлтийн үндэслэл
насныхан оролцох боломж хязгаарлагдмал		<i>иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.</i>
Засаг даргад нэр дэвшүүлэх нь Засаг даргын мэдэлд	Бүтэн өдрийн санал хураалт — иргэн бүр оролцох эрхтэй.	<i>Хариуцлагын тогтолцоо, ил тод байдал сайжирна.</i>
Хорооны Засаг даргад дээд боловсрол, багийн Засаг даргад бүрэн дунд боловсрол шаардана	Баг, хорооны Засаг даргад аль алинд бүрэн дундаас дээш боловсрол	<i>Тэгш бус шаардлагыг Үндсэн хуулийн зарчимд нийцүүлнэ</i>

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар иргэд нутаг дэвсгэрийнхээ асуудлыг өөрсдөө шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдэж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх шууд механизм ажиллана. ИНХ-ын даргын урамшууллын зардалд жилд 16.2 тэрбум төгрөг шаардлагатай. Ний зардлын 87.7% нь орон нутгийн багуудад зориулагдах бөгөөд 1,851 мэргэшсэн сонгуульт ажлын байр бий болно. Ингэснээр Монгол Улсын Үндсэн хуулийн 16.9, 59.2, 60.1, 60.2 дахь хэсгүүдэд заасан нутгийн өөрөө удирдах ёсны зарчимтай бүрэн нийцнэ.

Монгол Улсын засаг захиргааны анхан шатны нэгжийн засаглалд 2022 оноос үүссэн хямралыг шийдвэрлэх үр дүнтэй арга зам бол хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах явдал юм. Хуулийг дагасан журам, зөвлөмж гаргаснаар энэ асуудлыг шийдэх боломжгүй нь тандан судалгааны тайлангаас харагдаж байна.

Тус хуулийн төсөл нь ИНХ-ын 4 жилийн гацааг арилгах бодит механизм болох эерэг үр дүнтэй байгаа бөгөөд шууд ардчиллыг дэмжсэн, иргэдийн оролцооны эрхийг эрхийг анхан шатны нэгжид хангах ач холбогдолтой болно.